



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: **МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ, ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ**

Хөтөлбөрийн нэр: **БАГШ, БАЙГАЛИЙН УХААНЫ БОЛОВСРОЛ (БИОЛОГИ)**

Индекс: **D011402**

Шинжээчийн баг:

Ахлагч:	У.Мягмаржав
Гишүүд:	М.Бүрнээ
	Г.Онолрагчаа

Он сар өдөр: 2022.03.23

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

Монгол үгс

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БУББ	Багш, байгалийн ухааны боловсрол (Биологи)
БУС	Байгалийн Ухааны Салбар
БЦ	Багц цаг
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУ	Боловсрол шинжлэх ухаан
ДНХ	Дезоксирибонуклейн хүчил
ДООБ	Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗХШҮА	Захиргаа, хяналт шинжилгээ, үнэлгээний алба
КОНА	Номын сангийн автоматжуулсан программ
ИДСК	Их, дээд сургууль, коллеж
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ӨҮТ	Өөрийн үнэлгээний тайлан
СҮД	Суралцахуйн үр дүн
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХЧБХ	Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс
ШУС	Шинжлэх Ухааны Сургууль
ЭШ	Эрдэм шинжилгээ
ЭШХ	Эрдэм шинжилгээний хурал
Гадаад үгс	
CDIO	Conceive Design Implement Operate
JCR	Сэтгүүлийн импакт факторын мэдээллийн тайлан
PDS	Бүтээлийн хулгайгаас урьдчипан сэргийлэх, бүтээлийн хулгайг илрүүлэх
SiSi	МУИС-ийн СиСи сургалтын мэдээллийн систем

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны сургууль School of Arts and Sciences, National University of Mongolia /NUM/	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Багш, Байгалийн ухааны боловсрол (Биологи)	
Индекс	D011402	
Шинжээчид	<p>Ахлагч: У.Мягмаржав Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн бакалаврын хөтөлбөрийн агуулга, судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан</p> <p>Гишүүд: М.Бүрнээ Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Биоанагаахын сургуулийн багш, доктор</p> <p>Г.Онолрагчаа Монгол улсын боловсролын их сургуулийн багш, доктор</p>	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн мэргэжилтэн Г.Даваажаргал	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022-03-14 Даваа гараг	
	09:00-10:30	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн Ажлын албаны захирал О.Янжмаа үг хэлж, шинжээчийн багийг хүлээлгэн өгнө.
		Шинжээчийн багийн ахлагч магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулна
		Сургуулийн захирал үг хэлнэ Хөтөлбөрийн товч танилцуулга /тайлан бичсэнээс хойших мэдээллийг оруулах/
	10:30-11:30	Сургуулийн орчинтой танилцана
	11:30-13:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авна
	13:00-14:00	Үдийн завсарлага
	14:00-15:00	Багш нартай уулзана
	15:00-17:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авна
17:00-17:30	Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг хийнэ	

	2022-03-15 Мягмар гараг	
	09:00-09:30	Шинжээчийн багийн уулзалт
	09:30-10:30	Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзалт
	10:40-11:40	Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзалт
	11:50-12:50	Оюутнуудын төлөөлөлтэй уулзалт
	13:00-14:00	Үдийн завсарлага
	14:00-16:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	16:00-17:00	Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
	17:00-17:30	Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад танилцуулах
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Биологийн багш бэлтгэсэн түүх

Биологийн тэнхим МУИС байгуулагдсан анхны жил буюу 1942 онд Багш нарын факультетийн бүрэлдэхүүнд байгуулагдсан бөгөөд тухайн үед хүн эмнэлэг, мал эмнэлэг, багшийн ангийн оюутнуудад биологийн мэргэжлийн хичээлүүдийг заах ажлыг хариуцан гүйцэтгэж байсан. Биологийн тэнхим нь Химийн тэнхимтэй хамтран 1951 оноос эхлэн дунд сургуулийн хими-биологийн багш бэлтгэх бие даасан салбар болон үйл ажиллагаагаа өргөжүүлсэн. Ийнхүү МУИС нь:

- 1942 оноос эхлэн багш мэргэжилтэн
- 1955 оноос Хими-биологийн багш
- 1959 оноос Биологийн багш
- 2010 оноос Биологи, байгаль шинжлэлийн багш
- 2014 оноос Багш, байгалийн ухааны боловсрол (Биологи) мэргэжлээр тус тус Биологийн багш мэргэжилтнийг бэлтгэж ирсэн түүхтэй.

Хөтөлбөрийн боловсролын зорилго, чиглэл, онцлог

МУИС-ийн биологи болон боловсрол судлалын салбарын шилдэг судлаачид, доктор, профессор багш нарын хамтарсан баг Биологийн багшийг бэлтгэх хөтөлбөрт хичээл заадаг тул биологийн суурь шинжлэх ухааны онолын мэдлэгтэй, туршилт судалгаа хийх чадвартайгаас гадна заах арга зүйн ур чадварыг хослуулан эзэмшдэг

Багш, байгалийн ухааны боловсрол (Биологи) хөтөлбөрийн зорилго нь бакалаврын боловсролын агуулга, арга зүй, үнэлгээ, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг хангаж, амьд биеийн бүтэц, амьдралын үйл ажиллагаа, ангилал зүй, гарал үүсэл, өсөлт, үржил хөгжил, шалгарал, хувьсал өөрчлөлтийн зүй тогтол, биологийн системд явагддаг онол, хууль, туршилт судалгааны аргуудыг судалж, хүрээлэн буй орчин, байгалийн юмс үзэгдлийн учир шалтгааныг биологийн шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлан заах арга зүйг эзэмшүүлэхэд оршдог.

Багшлах боловсон хүчин

МУИС-ийн Биологийн тэнхимийн багш, ажилтны бүрэлдэхүүн

- ✓ Профессор, зөвлөх профессор 9+1
- ✓ Дэд профессор, зөвлөх дэд профессор 11+4
- ✓ Ахлах багш 8
- ✓ Багш 3
- ✓ Туслах ажилтан, лаборант 9
- ✓ Нийт 45

Хөтөлбөрийн чиглэлээр эрдэм шинжилгээний бүтээл

Хөтөлбөрийн 14 (давхардсан тоогоор) багш Web of Science, Scopus бүртгэлтэй сэтгүүлд 38 өгүүллийг хэвлүүлж урамшуулалд хамрагдсан. шинэ бүтээлийн 6 патент, 2 ашигтай загвар батлуулсан

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт

Ажил олгогчдын зүгээс төгсөгчдийн мэдлэг ур чадварын талаар 57.1% маш сайн, 42.9% сайн ажил олгогчийн шаардлагад ихэвчлэн болон бүрэн нийцдэг гэж үзсэн байна.

Төгсөгчдийн мэргэжлийн мэдлэг чадвар 70%, бичих ур чадвар 60%, ярианы ур чадвар 60%, компьютер интернет ашиглах чадвар 60% маш сайн байгаа бол бизнес эрхлэх чадвар 33% муу олгосон гэж үзжээ.

Төгсөгчдийн ажил эрхлэлт

МУИС-ийн Биологийн тэнхимийн багшийн ангийг төгсөгчдийн 95% нь мэргэжлээрээ ажиллаж байна. Тус хөтөлбөрийн 2017-2020 оны төгсөгчдийн 84.6 % ажил эрхэлж, 76.9% нь мэргэжлээрээ ажил эрхэлж байгаа бол 15.4% нь ажил эрхлээгүй байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- БШУ-ны Сайдын 2014 оны А/174 дүгээр тушаал “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага” БШУ-ны Сайдын 2014 оны А/78, 2014 оны А/52 дугаар тушаал
- Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт-Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт
- Хөтөлбөрийн харьцуулсан судалгааны нотлох баримт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш мэргэжлийн хөтөлбөрийн хандлагуудыг судалсан, Либерал арт боловсролыг баримталдаг “Bachelor of Science in Education” хөтөлбөртэй сургуулиудаас Бостоны их сургууль, Маруландын их сургуулиудын кредит цагийг сургалтын нийт төлөвлөлт, мэргэжлийн хичээлүүдийн болон боловсрол судлалын багц цагийг судалсан байна.
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн АНУ-ын Utah, Калифорны Perris, Пенсилваны Indiana их сургууль дотоодын МУБИС болон Ховд Их Сургуулийн хөтөлбөрүүдтэй харьцуулан судалж биологийн ШУ-ы болон дидактикийн хичээлүүдийг сонгон хөтөлбөртөө тусгасан байна.

Анхаарах асуудал:

- Хөдөлмөрийн зах зээл дэх сонирхогч талуудын эрэлт хэрэгцээний судалгааг авч дүн шинжилгээ хийх

Зөвлөмж:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээний судалгааг STEEP гэх мэт судалгааны аргыг ашиглан дүн шинжилгээ хийж, үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо боловсролын тухай хууль, дээд боловсролын тухай хуулийн холбогдох заалтуудад үндэслэн боловсруулсан байна.
- Хөтөлбөрийн боловсролын зорилгыг сургууль, бүрэлдэхүүн сургууль, тэнхимийн зорилготой уялдуулан боловсруулж, хөтөлбөрийн төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадварыг тодорхойлсон
- МУИС-ийн бакалаврын хөтөлбөрүүдийн эрхэм зорилго, олгох мэдлэг, ур чадвар, хандлага, ирээдүйн ажлын байр, томоохон ажил олгогч зэрэг мэдээллийг тусгасан товч танилцуулгатай мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулгыг хэвлэмлээр болон хөтөлбөрийн цахим хуудсаар оюутан, эцэг эх, багш, сонирхсон хүмүүст тогтмол түгээдэг, сургалтын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг баталгаажуулан МУИС-ийн вэбсайт, SiSi сургалтын удирдлагын системд цаг тухай бүрд оруулдаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн боловсролын зорилгыг тодорхойлсон.
- Төгсөгчийн эзэмших ур чадварыг (компетенц) Хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, дадал, төлөвшил(6); Хүмүүстэй харилцах ур чадвар (3) ;Биологийн ШУ-ы эзэмших мэдлэг, ур чадвар,чадамж (8); Боловсрол судлал дидактикийн хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар (12) гэсэн 4 чиглэлээр нийт 29 ур чадварыг тодорхойлсон.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилгыг томъёолох
- Хөтөлбөрөөр төгсөгчийн загвар боловсруулах
- Хөтөлбөрөөр суралцагчийн суралцахуйг үр дүнг тодорхойлох
- Төгсөгчид болон ажил олгогчдын саналыг хөтөлбөрт тусгах

Шаардлага:

Бакалаврын хөтөлбөрийн нийтлэг шаардлагын 2.1-ын хөтөлбөрийн танилцуулга хэсгийн 2.1.5-д хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүн буюу оюутны эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, чадамжийг бичих тухай тусгасан байдаг. Иймд

- Хөтөлбөрийн боловсролын зорилтуудыг тодорхойлох (Program Educational Objectives-PEOs) суралцахуйн үр дүнг тухайн хөтөлбөрөөр суралцаж төгссөн мэргэжилтнүүдийн мэдлэг, чадвар, хандлагын түвшин талаас нь тодорхойлох
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох (Program Learning Outcomes-PLOs)-суралцахуйн үр дүнг тухайн хөтөлбөрөөр суралцаж байгаа оюутны сургалтын нийт хугацаанд эзэмших мэдлэг, чадвар, хандлага талаас нь тодорхойлох
- Хичээлийн суралцахуйн үр дүнгүүдийг тодорхойлох (Course Learning Outcomes-CLOs) суралцахуйн үр дүнг тухайн хөтөлбөрт байгаа аль нэг хичээлээр оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага талаас нь тодорхойлох
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг чадвар ба хөтөлбөрийн зорилго зорилтуудын хоорондын уялдаа холбоо хамаарлыг (матриц) хийх
- Хөтөлбөрийн зорилгын өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлж, оролцогч талуудыг саналыг тусган сайжруулах үйл ажиллагааг тогтмолжуулах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаал
- БШУ-ны сайдын 2014 оны А/78 тоот тушаал
- Багш мэргэжлийн хөтөлбөрийн хичээлүүдийн харьцааг тогтоох зорилгоор 2014 оны 09 сарын 11-д байгуулагдан ажилласан МУИС-д “Багш” мэргэжлийн бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн хурлын тэмдэглэл
- МУИС-ийн хөтөлбөрийн Ерөнхий хорооны хурлаар хэлэлцэж МУИС-ийн захирлын 2014 оны 11 сарын 10-ны өдрийн А/369 тоот тушаалаар баталсан сургалтын хөтөлбөр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор хөтөлбөрийн ерөнхий хороо, салбар хороодууд тодорхой төлөвлөгөөтэй ажлууд зохион байгуулж, тайлагнадаг.
- Сургалтын төлөвлөгөөнд тусгасан мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдээр төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадварын хоорондын хамаарлыг харуулсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, үр дүнг тооцох

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрөөр төгсөгчдөд эзэмшүүлэх мэдлэг чадвар хандлагыг тодорхойлсон
- Шинжлэх ухааны үндсэн салбаруудыг хамарсан чөлөөт мэдлэг буюу “либерал арт” уламжлалд суурилсан сургалтын хөтөлбөртэй. Ерөнхий суурь хичээл (А) 36 багц цаг, Мэргэжлийн суурь хичээл (Б) 9 багц цаг, Мэргэжлийн хичээл (В) 60 багц цаг, Чөлөөт сонголтын хичээл (Г) 15 багц цаг, Гамшгаас хамгаалах менежментийн үндэс 1 багц цаг, нийт 121 багц цаг бүхий, тайлбар болон төгсөгчдөд тавих хөтөлбөрийн шаардлагыг тусгасан байна. Чөлөөт сонголтын хичээл (Г) нь мэргэжлийн сонгон судлах хичээлийг үндсэн мэргэжлийн тодорхой салбараар нарийсган, сонгон суралцах боломжид нийцүүлэх зорилготой, 15 багц цагийн багтаамжтай.
- Чөлөөт сонголтын хичээлийг сургалтын төлөвлөгөөний Б2, В2 хичээлээс сонгон судалж болохоор сүүлийн 2 жилд өөрчлөлт оруулсан.

- Сурган хүмүүжүүлэх танилцах дадлага 2 багц цаг, сурган хүмүүжүүлэх дадлага I-4 багц цаг, сурган хүмүүжүүлэх дадлага II-6 багц цаг, хээрийн дадлага 2 багц цаг байна
- Боловсрол судлалын чиглэлээр нийт 30 багц цаг төлөвлөгдсөн.
- Нийт 28 хичээлийн хөтөлбөрийг сургалтын нэгдсэн албанаас гаргасан “Хичээлийн хөтөлбөр боловсруулах зааврын дагуу боловсруулсан
- ЕБС-ийн хөтөлбөртэй уялдуулан шинэчлэн сайжруулдаг
- Нэг хичээлийг 2-оос дээш багш заах сонголттойгоор төлөвлөдөг.
- Хичээл сонголт, бүртгэл гэх мэт сургалтын үйл ажиллагаа удирдлага мэдээллийн SISI системтэй
- МУИС-ийн Сургалтын журмын 4.1.6, 4.5.9-д оюутны нэг улирал болон хичээлийн жилд судлах багц цагийн хэмжээг тогтоож өгсөн байдаг. Мэргэжлийн заавал судлах хичээлийн багц цагийн харьцаа лекц семинар лаб 50:14,8:35,2
- “МУИС-ийн суралцагчийн дадлагын журам”-ын хүрээнд хөтөлбөрийн багш болон байгууллагын мэргэжилтний удирдлагын дор түшиц сургууль дээр багшлах дадлага хийдэг. Ургамал, амьтан судлалын хээрийн дадлага хийх баазтай.
- Хөтөлбөрийн хорооны шийдвэрээр сургалтын төлөвлөгөөнд мэргэжлийн суурь чиглэлд зарим хичээлийг нэмэх, зарим хичээлийг сонгон судлах хэлбэрээр тусгах, тус хөтөлбөрийн сурган хүмүүжүүлэх дадлагын цагийг нэмэгдүүлэх, зарим хичээлийн улирал индекс, бүтцийн (лекц сем лаб) өөрчлөлтүүдийг хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Сургуулийн эрхэм зорилго суралцахуйн үр дүнгийн хамаарлын матриц хийх
- Сургалтын төлөвлөгөөний ерөнхий бүтэц бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага А/174-ын хүрээнд сайжруулан боловсруулах
- Удирдлага мэдээллийн системийн серверийн үйл ажиллагаа доголддог.
- Хичээл хоорондын залгамж холбоог харуулсан график /хөтөлбөрийн мод/ хийгдсэн хэдий ч зарим холбоосыг гүйцээн сайжруулах
- Сургалтын төлөвлөгөөнд тусгасан сурган хүмүүжүүлэх дадлагын индексүүд хөтөлбөрийн хичээлүүдийн залгамж холбоонд өөр индексээр тусгагдсан.
- Оюутны дадлагын удирдамж, хамтран ажилладаг байгууллагуудтай хийгддэг гэрээ, оюутны дадлагын тайлантай боловч түүнд дүн шинжилгээ хийх

Шаардлага:

- Сургалтын хөтөлбөрийн бүтэц дэх ерөнхий суурь чиглэл (А), Мэргэжлийн суурь чиглэл (Б), Мэргэжлийн чиглэл (В)-ийг тус бүрд нь заавал болон сонгон судлах гэсэн 2 хэсэгтэйгээр төлөвлөх
- Сургалтын төлөвлөгөөний бүтцийг сайжруулж, ерөнхий суурь хичээлийн төлөвлөлтөд судлагдахууны чиглэлийг бус, хичээлийн нэр багц цагийг тодорхой тусгах
- Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын саналыг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах
- Хичээлийн хөтөлбөрийн (CLO) суралцахуйн үр дүнг тодорхойлох
- Сургалтын төлөвлөгөөний Б2,В2 сонголтлоос хийсэн хичээлийн багц цагийг чөлөөт сонголтын 15 багц цагт багтаан дипломын бичилтэд тооцон бичдэг байх
- Хөтөлбөрийн хичээлүүдийн залгамж холбоог сайжруулан зураглах

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн сургалтын журмын 1.10.23-25 д сургалтын аргуудыг заасан байна.
- МУИС-ийн цахим сургалтын журмын хүрээнд цахим хичээл явагддаг.
- МУИС-ийн суралцагчдаас улирал бүр багшийн заасан хичээл, сургалтын арга зүйн талаар сэтгэл ханамжийн судалгаа авдаг.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Идэвхтэй сургалтын аргуудыг лекц (танхимын сургалт) семинар (6), лабораторийн хэлбэрт (2) харгалзуулсан

- Microsoft Teams платформыг сургалтад ашигладаг.
- Цахим сургалтын платформуудын зааварчилгааг багш суралцагчид өгч ажилладаг.
- МУИС-ийн суралцагчдын багшийн заасан хичээл, сургалтын арга зүйн талаарх сэтгэл ханамжийн судалгаагаар тэнхимийн багш нар 87.66% нь хангалттай сайн гэж үнэлэгдсэн

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг сайжруулахад CDIO сургалтад хамрагдсан тэнхимийн багш нарын оролцоог нэмэгдүүлэх
- Хөтөлбөрийн багш нарын хичээл болон сургалтын арга зүйн талаарх сэтгэл ханамжийн байдлыг үнэлэх
- Сургалтын арга зүйн талаар тэнхимийн зүгээс судалгаа хийх

Шаардлага:

- Сургалтын арга зүйн судалгааг хийж үр дүнг хөтөлбөрийн сайжруултад ашиглах
- Тус хөтөлбөрөөр суралцагчдын багшийн заасан хичээл, сургалтын арга зүйн талаарх сэтгэл ханамжийн үр дүнг ялган тооцох
- Сургалтын арга зүйг хичээлийн хөтөлбөрт тусгах

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагчийн мэдлэг чадварыг үнэлэх аргачлалыг МУИС-ийн сургалтын журмын 2.4; 4.6 –д тусгасан байна.
- Явцын болон төгсөлтийн шалгалтын журамтай
- Суралцагчийн сурлагын амжилт, ахицын талаарх судалгаатай

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Мэргэжлийн хичээлийн үнэлгээг хийхдээ 9 баллын системээр, хувьчилсан оноо, үсгэн болон тоон үнэлгээг ашиглана.
- Үнэлгээний нэмэлт 10 тэмдэглэгээг ашигладаг.
- Хичээлийн хөтөлбөрт суралцагчийн үнэлгээний аргыг тусгасан.
- Мэргэжлийн 15 хичээлийн хөтөлбөрийн үнэлгээний аргыг судалсан

- Багш нарын үнэлэх арга аргачлал, шалгалтын үр дүн үнэлгээний шударга байдлын талаарх суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг 2016-2020 оны хооронд хавар намрын улиралд тогтмол авдаг, 2020 оны байдлаар дундаж үзүүлэлт 2.66 болж өссөн.

Анхаарах асуудал:

- Хичээл нэг бүрийн үнэлгээнд дүн шинжилгээ, анализ хийх /шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд шинжилгээ хийх
- Блумийн таксономи, үнэлгээний рубрикийг хичээлийн хөтөлбөрт тусгах .

Зөвлөмж:

- Хичээл нэг бүрийн шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сорилын санд суралцах түвшин бүрээр шинжилгээ, анализ хийж үр дүнг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах
- Үнэлгээний зорилго, шалгуур, шалгуурын түвшин бүрийн оноо, хийх аргачлалыг тусгасан үнэлгээний рубрикийг хувилбартайгаар боловсруулах

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

Өөрийн үнэлгээтэй танилцаж, МУИС-ийн ББУБ хөтөлбөр хэрэгжүүлж буй хичээлийн II байрны орчин нөхцөлтэй танилцахад:

- МУИС-ийн Төв номын сангийн орчин нөхцөл нь суралцагчдын таатай орчинд суралцах боломжоор бүрэн хангасан, 3-р давхарт байрлах Байгалийн Ухааны Уншлагын танхимтай (амрах, чөлөөт цагаа өнгөрөөх орчин, бие засах өрөө, суурин компьютер гэх мэт).
- Микробиологи, Биохими, Генетик молекул биологи, Амьтан судлал, Ургамал Судлал, Молекул эсийн биофизикийн, болон компьютерын лабораториудтай, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.
- Оюутны дотуур байр нь ариутгал (хортон шавж, Ковид) цаг тухайд нь хийгддэг, Өрөөндөө 2 эсвэл 4 оюутан байх боломжтой, давхар бүрд хоол хийх, идэх өрөө, дүш, угаалгын болон оюутны бие даах өрөөтэй.
- Оюутны I дотуур байранд эрүүл мэндийн төв1 эмч, 1 сувилагчтай ажилладаг, уг төвөөр өдөрт дунджаар 10-15 оюутанд туслалцаа авдаг.
- Хичээлийн II байранд ариун цэврийн өрөө нь давхар бүрээр эрэгтэй, эмэгтэй өрөөг хангаж өгсөн (3-р давхарт ЭР, 4-р давхарт ЭМ гэх мэт).

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нарын өрөө, мөн лекц, семинарийн 10, лабораторийн 8 болон оюутны бие даах 1 өрөө нь сургалт явуулах төхөөрөмжөөр хангагдсан.
- Сургалт-судалгааны/судалгаа-сургалтын лабораториуд нь орчин үеийн багаж тоног төхөөрөмжөөр зохих түвшинд хангагдсан, лабораториудын хүртээмж сайн, нэг оюутанд ноогдох талбайн хэмжээ улсын стандартад нийцсэн.
- Лабораторийн чадавхыг сайжруулах ажлын хүрээнд МУИС өөрийн санхүүжилтээр болон, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар өөрсдийн төслийн хүрээнд багаж тоног төхөөрөмж авдаг.
- МУИС-ийн оюутны байр нэг өрөөнд байрлах оюутны тоо, оюутанд ноогдох метр квадрат, усанд орох байр, хоолны өрөөтэй.
- Хичээлийн жил дуусах үед суралцагч нараас сургалтын орчны талаар авдаг санал асуулгын дүнгээс харвал сүүлийн 3 жилийн дунджаар 2.64 (1 – цөөн тохиолдолд санал нийлдэг, 2- ихэнх тохиолдолд санал нийлдэг, 3 – бүрэн санал нийлдэг) байгаа нь сургалтын орчин хэрхэн бүрдсэнийг илтгэж байна.
- Төгсөгчдийн санхүүгийн дэмжлэгтэйгээр оюутны бие даалтын төвийг тохижуулсан.
- Хичээлийн байр болон оюутны байранд Утастай, утасгүй интернет хүртээмжтэй.

Анхаарах асуудал:

- Суралцагчид чиглэсэн хоолны газрын үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Утасгүй интернетийн хурдыг нэмэгдүүлэх

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

танилцлаа..

- Хичээлд хэрэглэгдэх үзүүлэн таниулах материал нь амьтан, ургамал судлал болон микробиологийн хичээлийн хүрээнд хангалттай сайн бүрдсэн, тэдгээрийн хадгалалт сайн. Амьтан судлал (Сээр нуруутан, Сээр нуруугүйтэн) хичээлийн хүрээнд шавжийн эталон санг баг төрлөөр, Хатуу далавчтан, Шулуун далавчтан, Хос далавчтан гэх мэтээр бүрдүүлэн хадгалж байгаа (100 зүйлийн 20,000 гаруй бодгаль) бол хичээлийн II байрны 422 тоотод Сээр нуруутан амьтдыг анги бүрээр ж.нь: Загас (40 зүйлийн 250 бодгаль), хоёр нутагтан (26 зүйлийн 253 бодгаль), хөхтөн (100 зүйлийн 500 гаруй бодгаль), шувуу (20 зүйлийн 394 бодгаль) гэх мэтээр чихмэл хийж ангилан хадгалсан. Микробиологийн хичээлд өргөн хэрэглэдэг түгээмэл бактериудын байнгын бэлдмэлийн сан бүрдсэн.
- Сургалтад болон дадлага практикт хэрэглэгдэх ном, гарын авлагыг багш нар бичиж, орчуулж хэрэглэж байна. Лаборатори ордог хичээл бүр (тухайлбал: Биохими, микробиологи, ургамал судлал гэх мэт) өөрийн дадлага ажлын гарын авлагатай, зааварчилгаатай байна.
- Багаж тоног төхөөрөмж хүртээмжтэй.
- Генетик, амьтан судлал гэх мэт лаборатори ордог хичээлүүд өөрийн E-контентыг YOUTUBE-д байрлуулах видео хэлбэрээр хийж, цар тахлын үед оюутнуудад хүргэн ажиллаж байсан. Генетикийн 13 видео хичээлтэй танилцсан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Амьтан, ургамал судлал болон микробиологийн хичээлийн хүрээнд хэрэглэж буй хичээлийн биет үзүүлэн хангалттай сайн бүрдсэн. Үүнд: хөхтөн, шувуу, шавж, дээд, доод ургамал зэргийн маш олон төрөл, зүйлийн чихмэл, хуурай болон нойтон бэлдмэл бэлдэж сургалтад хэрэглэж байна.
- Сургалтад зориулсан мэргэжлийн ном сурах бичиг, гарын авлагыг хөтөлбөр хэрэгжүүлэгч багш бичиж хэвлүүлсэн байна. Үүнд: боловсрол судлалын ном сурах бичиг 17, биологийн мэргэжлийн сурах бичиг 7, гарын авлага 53 байна.
- Гадаад хэлнээс орчуулсан болон монгол хэлээр хэвлэгдсэн мэргэжлийн ном сурах бичгийн сан бүрдүүлэх, худалдаж авахад МУИС ихээхэн анхаарч ажилласан байна.

Анхаарах асуудал:

- Хичээлийн үзүүлэн таниулах материалын хувьд Амьтан, Ургамал судлал, Микробиологийн хичээлээс бусад мэргэжлийн хичээл, суурь онолын хичээлийн энэ төрлийн үзүүлэн таниулах материалын тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлэх.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн Төв номын сангийн орчин нөхцөл нь суралцагчдын таатай орчинд суралцах боломжийг бүрэн хангасан, 3-р давхарт байрлах Байгалийн ухааны уншлагын танхим нь оюутан суралцагчдын хэрэгцээг бүрэн хангасан байна (амрах, чөлөөт цагаа өнгөрөөх орчин, бие засах өрөө, суурин компьютер гэх мэт).
- Номын сан 4-р сараас 24 цагийн уншлагын танхимтай болохоор төлөвлөн ажиллаж байна..
- Магистр, докторын уншлагын танхимд төгсөгчдийн эрдмийн ажлыг судлах боломжтой

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Номын сангийн багтаамж, орчин сайн хүртээмжтэй, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангагдсан Ж.нь: Bookeye4, Kodak ScanMate i1150 зэрэг сканерууд гэх мэт.
- Багш, суралцагчдын орчин үеийн ном товхимол, эрдэм шинжилгээний өгүүлэлтэй танилцах хэрэгцээг хангах зорилгоор олон улсын онлайн сангийн эрхийг худалдан авч хэрэглээнд нэвтрүүлсэн.
- Уншигч суралцагчдын санал болгосон номын жагсаалтыг гарган зохих хэмжээгээр санд хуримтлуулсан байна

Анхаарах асуудал:

- Сургуулийн номын санд нэвтэрсэн цахим мэдээллийн санг сургалтдаа ашиглах
- Багш, суралцагч нарт шинээр нэвтэрч буй технологи, арга аргачлалыг сайтар сурталчлан таниулах тал дээр анхаарч ажиллах.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- “МУИС-ийн хөтөлбөрийн хорооны журам”-ыг их сургуулийн захирлын 2016 оны А/347 тоот тушаалаар батлан, хэрэгжүүлж байна.
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд МУИС-ийн сургалтын үйл ажиллагааны холбогдох журам (10), тушаал (2), удирдамж (1) зэрэг баримт бичгүүдийг үндэслэдэг байна.
- Биологийн тэнхимийн хөтөлбөрийн дэд хороо нь ШУС-ийн захирлын 2018 оны 5 сарын 1-ний өдрийн Б/80 болон 2020 оны 3 сарын 26-ны өдрийн Б/25 тоот тушаалаар батлагдсан бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.
- Тус хөтөлбөрт тусгагдсан хичээлийг Биологи (24), Сурган сэтгэл судлалын тэнхимийн (6) багш нар болон төгсөгчид, ажил олгогчид, мэргэжлийн байгууллага, оюутны төлөөллийг оруулан хэрэгжүүлж байна.
- “МУИС-ийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-г боловсруулан, 2016-2018, 2019-2021, 2022-2024 онуудад 3 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.
- Тус төлөвлөгөөний хүрээнд Багш, байгалийн ухааны боловсрол хөтөлбөрөөс богино хугацааны ажлын төлөвлөгөөний дагуу уг мэргэжлээр суралцах оюутны тоог нэмэгдүүлэхэд анхаарч, тэтгэлэг, төслүүдэд хамруулах, хөтөлбөрийн сурталчилгаа, мэдээллийг үр дүнтэй хүртээмжтэй түгээх зэрэг ажлыг зохион байгуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн хувьд хөтөлбөр хариуцсан нэгж буюу тэнхимүүд багш, ажилтнаар дамжуулан суралцагчдын санал бодлыг сонсохын зэрэгцээ сэтгэл ханамжийн судалгааны дүн, оюутны санал хүсэлтэд тулгуурлан хөтөлбөрийг сайжруулах, шинэчлэх ажлыг тогтмол гүйцэтгэдэг.
- 2019 оноос “МУИС-д технологийн коллеж төгсөгчийг суралцуулах түр журам” хэрэгжүүлж эхэлсэн.
- Тус хөтөлбөрийн хэрэгжилтэд багш нар лекц, семинар, лабораторийн хичээл заахын зэрэгцээ оюутны бие даалт, эрдэм шинжилгээний ажлыг удирдах байдлаар оролцож, харин суралцагчид багшийн удирдлагаар төсөл, хөтөлбөрт хамрагдах, эрдэм шинжилгээний ажил хийх, илтгэл хэлэлцүүлэх, уралдаан тэмцээнд хамрагдах, мэргэжлийн клуб, дугуйлан хичээллүүлэх зэргээр танхимын бус сургалтын үйл ажиллагаанд оролцдог.
- Сургалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн систем (SiSi)-ийг хэрэгжүүлж, сургалтын үйл ажиллагааг ил тод, оролцогч талуудын хяналттай зохион байгуулах болсон төдийгүй хөтөлбөр болон сургалтын үйл ажиллагаатай холбогдох санал, гомдлыг вэб-д суурилсан сургалтын мэдээллийн систем (SiSi)- ээр дамжуулан шийдвэрлэдэг.

Анхаарах асуудал:

- Сургалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн систем (SiSi)-ийг боловсронгуй болгох, оргил ачааллын үеийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарах

Зөвлөмж:

- Хөтөлбөрт суралцагчдыг танхимын бус сургалтад хамруулах, тухайлбал мэргэжлийн клубийн үйл ажиллагааг тогтмолжуулах, сайжруулахад хөтөлбөрийн багш нар идэвх, санаачилгатай ажиллах

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Сүүлийн жилүүдэд олон улсын нэр хүндтэй их сургууль болон олон улсын сангууд, бусад мэргэжлийн байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд эдгээр хэлцлүүдийн хүрээнд хамтарсан судалгаа, төсөл хэрэгжүүлэх, докторын дараах судалгаа хийх, гадаадын их, дээд сургууль, лабораториудад ажиллах, сургалт семинарт хамрагдах байдлаар хөтөлбөрийг хэрэгжүүлэгч боловсон хүчний чадавхыг нэмэгдүүлэх, сургалт, судалгааны орчныг сайжруулах, ижил мэргэжлийн хөтөлбөрийг судлах болон загвар болгох замаар хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэх, оюутны оролцоог нэмэгдүүлэх, оюутны хөгжлийг дэмжих, сайжруулах ажлууд хийгдсэн байна.
- Сүүлийн 5 жилийн хугацаанд хөтөлбөрийн 6 багш олон улсын хурал, семинарт оролцсон, 13 багш гадаадын их сургууль, лабораториудад ажилласан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн жилүүдэд хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн багш нар олон улсын хамтарсан 11 төсөл, ШУТС-ийн 6 төсөл, залуу судлаачдыг дэмжих судалгааны грантын тэтгэлэгт 3 төсөл, гадаадын санхүүжилттэй 24, дотоодын санхүүжилттэй 7 төсөлт ажилд оролцон хэрэгжүүлж байна. Үүнээс багш, байгалийн ухааны хөтөлбөрийн хүрээнд:
- 2016 онд МУИС ба Уппсала их сургуулийн хамтарсан “Phylogeny and Taxonomy of *Calandrella*, *Alauda* and *Eremophila larks* in Mongolia, Uppsala University (in collaboration with prof.Per Alstrom) болон Олон улсын Рамсарын Конвенцын зөвлөлтэй хамтарсан “Ramsar sites SIS Update and Capacity Building” төслүүд
- 2015-2016 онд НҮБ, Дасан зохицох сантай хамтран “Biodiversity and Society of Ulz, Uvs and Tes River Basin” төсөл
- 2015 онд Рамсарын бүс нутгийн төв байгууллагатай хамтран “National Ramsar Helm wetland and site manager training”, Bloomsbury Publishing and AC Black Helm байгууллагатай хамтран “Birds of Mongolia”, азийн махчин шувуу судлах, хамгаалах Олон улсын сүлжээ байгууллагатай хамтарсан “Sedentary Raptor of Asia” зэрэг төслүүд
- 2014 онд АНУ-ын Колорадогийн их сургуультай хамтарсан “Taxonomy and phylogeny of Barn swallow in Mongolia” төсөл
- 2012, 2016 онд Харвардын их сургуультай хамтран “Diversification and phylogeography of Palearctic birds” зэрэг төслийг амжилттай гүйцэтгэсэн байна.

- Олон улсын нэр хүндтэй их сургууль, байгууллагатай хамтарсан төсөл, хөтөлбөр олноор хэрэгжиж буй нь хөтөлбөрийн багш нар цаашид хамтын ажиллагаагаа олон чиглэлээр өргөжүүлэх боломж байгааг илэрхийлж байна.
- Хөтөлбөрийн багш нарын мэргэжлийн үйлчилгээний хүрээнд шувуу судлал, байгаль хамгаалал, сурталчилгааны чиглэлээр Цэнгэг усны нөөцийн газар, байгаль хамгаалах төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Монгол маркын газар зэрэг байгууллагатай хамтран ажиллаж байна. Тухайлбал,
- Жил бүр “Дэлхийн нүүдлийн шувуудын өдөр”, “Дэлхийн байгаль хамгаалах өдөр” ажлын хүрээнд гэрэл зургийн уралдааныг зохион байгуулдаг.
- 2014-2016 онд “Гоёмсог шувуу”, “Монгол улсын үндэсний бахархалт шувуу”, “Монгол улсын үндэсний бахархалт цэцэг”, “Монгол орны ууль” зэрэг цуврал маркуудыг гаргажээ.
- Багш, байгалийн ухааны боловсрол хөтөлбөрийн багш нар улсын захиалгат болон аж ахуйн гэрээт ажилд идэвхтэй оролцдог. Тодруулбал:
 - Мэргэжлийн холбоодтой хамтран ажилласан -13 багш
 - Үйлдвэр үйлчилгээний байгууллагатай хамтран ажилласан -4 багш
 - Ажил олгогч эздийн холбоотой хамтран ажилласан -2 багш
 - Төрийн бус байгууллагын захиалгат ажилд -13 багш
 - Төрийн байгууллагатай хамтарсан – 18 багш
 - Хамтын ажиллагааны гэрээтэй – 20 багш
 - Хэрэгжүүлж буй ажлын тайлан бичдэг – 16 багш
 - Хамтын ажиллагааны арга туршлага дэвшүүлдэг – 14 багш
 - Нийгэмд чиглэсэн үйлчилгээ үзүүлэн ажилладаг – 22 багш
 - Оюутан суралцагчийн тэтгэлгийг “МУИС- суралцагчдад тэтгэлэг олгох нийтлэг журам”-аар зохицуулан хэрэгжүүлж байна. Багш, байгалийн ухааны боловсрол хөтөлбөрийн 4 оюутан Япон улсын Мицубиши корпорацийн болон МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг, 2 оюутан судалгааны төслийн тэтгэлэгт хамрагджээ. Мөн тус хөтөлбөрөөс хөнгөлөлттэй зээлд 2, буцалтгүй тусламжид 2, төрийн албан хаагчийн гэр бүлийн хөнгөлөлтөд 1, нийт 5 оюутан хамрагдсан байна.

Анхаарах асуудал:

- Мэргэжлийн хөтөлбөрт элсэгчдийн тоо хэт цөөн байгаа нь цаашид хөтөлбөрийн тогтвортой байдалд нөлөөлж болзошгүйг анхаарах
- Биологийн тэнхимийн төгсөгчдийн БИОТА холбооны үйл ажиллагааг сайжруулахад хамтран ажиллах

Зөвлөмж:

- Мэргэжлийн сурталчилгаа, таниулах үйл ажиллагаандаа элсэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан шинэлэг аргыг хөгжүүлэн, сайжруулах. Тухайлбал, хөтөлбөрт элсэгчид нь бусад улс орны ижил төстэй их сургуульд шилжин суралцах боломжийг судлах

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн санхүүгийн үйл ажиллагаа нь нягтлан бодох бүртгэлийн хууль болон бусад хууль тогтоомж, их сургуулийн санхүүгийн үйл ажиллагааны журмын дагуу сургалтын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлж байна.

- Биологийн тэнхимийн жил бүрийн ажлын төлөвлөгөөнд төсвийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг тусган хэрэгжүүлдэг.
- Сүүлийн жилүүдэд тэнхимийн үйл ажиллагаанд жилд дунджаар 1.8-2.3 тэрбум төгрөгийн төсвийг зарцуулжээ.
- Сургалтын үйл ажиллагаанд жилд дунджаар 88-105 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг худалдан авсан байна.
- Жил бүр 12-14 сая төгрөгийг багш, ажилтнуудын үйл ажиллагааг дэмжихэд зарцуулдаг.
- МУИС-ийн судалгааны ажлын санхүүжилтийн журмын дагуу тэнхимээс суурь судалгааны санхүүжилтэд 2019 онд 22 багш, 2020 онд 24 багш тус тус хамрагджээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС нь төрийн өмч дээр суурилан үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлаа өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар нөхдөг төрийн өмчийн сургууль. 2014-2015 оны хичээлийн жилээс их сургуулийн хэмжээнд төсвийн төлөвлөлт, орлого хуваарилалт, бүтээгдэхүүний өртөг тооцооллын шинэ журам хэрэгжиж байна.
- МУИС-ийн Санхүү, төлөвлөлтийн газраас нэг суралцагчид оногдох зардлыг багц цагаар тооцож төлөвлөх бөгөөд сургалтын төлбөр бүхэлдээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх буюу сургалтын үйл ажиллагаанд зарцуулагддаг. Тухайлбал, ШУС-ийн суралцагчийн төлбөр:
 - ✓ 2015-2016 оны хичээлийн жилд I түвшинд 74600, II ба III түвшинд 64300, IV түвшинд 50100 ₮
 - ✓ 2016-2017 оны хичээлийн жилд I түвшинд 80200, II түвшинд 74600, III ба IV түвшинд 64300 ₮
 - ✓ 2017-2018 оны хичээлийн жилд I түвшинд 86700, II түвшинд 84300, III түвшинд 78700, IV түвшинд 68400 ₮
 - ✓ 2018-2019 оны хичээлийн жилд I түвшинд 98600, бусад түвшинд 100700 ₮
 - ✓ 2019-2020 оны хичээлийн жилд I түвшинд 98600, бусад түвшинд 100700 ₮
- МУИС-ийн удирдах зөвлөлийн 2019 оны 8-р сарын 26 өдрийн 06 тоот тогтоолоор шийдвэрлэсэн оюутны дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээ 2019-2020 хичээлийн жилд:
 - ✓ оюутны I байрны өрөөний төлбөр (4 оюутан) хагас жилээр 420,000 жилээр 780,000 ₮
 - ✓ оюутны II байрны өрөөний төлбөр (4 оюутан) хагас жилээр 330,000 жилээр 660,000 ₮
 - ✓ оюутны Y байрны өрөөний төлбөр (2 оюутан) сарын 155,000 жилээр 1,550,000 ₮
 байна.
 - ✓ Санхүүжилт, мөнгө босгох чиглэлээр санаачилга гарган ажиллаж байгаагийн илрэл нь хамтран ажиллагч, түншлэгч байгууллагуудаас хамтарсан төсөл хэрэгжүүлж, санхүүжилтийг оюутанд сургалтын төлбөр төлөх, тэтгэлэг олгох, судлаачаар ажиллуулах болон сургалт, судалгааны лабораторийг тохижуулах, тоног төхөөрөмж худалдан авах сургалт, судалгааны үйл ажиллагаанд зарцуулсан байна.
- Хөтөлбөрийн үр дүнг нэмэгдүүлэх, хичээлийн орчныг сайжруулах зорилгоор тус тэнхим нь сургалтын лабораторийн багаж, төхөөрөмжөө байнга шинэчлэн сайжруулахад анхаарч ажиллаж байна. Тухайлбал, Микробиологи, Биофизик, Генетик, Ургамал судлал, Амьтан судлалын лабораториудад 574,114,442 төгрөгийн үнэ бүхий 90 гаруй тоног төхөөрөмж авч сургалт, судалгааны багаж, төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлсэн байна.

- Сүүлийн 5 жилд тэнхимийн профессор, багш нар 660 гаруй сая төгрөгийн санхүүжилттэй олон улсын байгууллагатай хамтарсан төсөл хэрэгжүүлж, оюутанд сургалтын төлбөр төлөх, тэтгэлэг олгох, судлаачаар ажиллуулах болон сургалт, судалгааны лабораторийг тохижуулах, тоног төхөөрөмж худалдан авах сургалт, судалгааны үйл ажиллагаанд зарцуулсан байна.
- Тэнхимийн багш нар гадаад, дотоод хамтын ажиллагаа, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж сургууль болон мэргэжлийн хөтөлбөрийн хөгжилд мөнгөн ба мөнгөн бус хөрөнгө оруулалтыг хийж ирсэн.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар төрийн болон хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний төсөл, захиалгат ажил, төсөвт ажлуудад оролцох, сургалт зохион байгуулах зэргээр ажилладаг. Тухайлбал, 2014-2020 онд багш нар нийт 73 эрдэм шинжилгээний төслийн ажлыг удирдан хэрэгжүүлж, 60 гаруй оюутан хамрагдсан байна.
- 2019-2020 оны хичээлийн жилд Багш, байгалийн ухааны боловсрол хөтөлбөрийн 2 оюутанд Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй төслөөс тус 1.5 сая ₮-ийн тэтгэлэг олгожээ.
- Оюутны суралцах үйл ажиллагааг дэмжих зорилгоор нэрэмжит тэтгэлэг олгох, оюутны эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, нэрэмжит лаборатори болон сургалтын өрөө тохижуулах ажлуудыг төрийн, хувийн хэвшлүүдийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн байна. Үүнээс Биохимийн инженерчлэлийн судалгааны лаборатори, Орчны судалгааны лаборатори, Шавж судлалын лабораторийг БСШУЯам, Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй хэрэгжсэн “Дээд боловсролын шинэчлэл төсөл”-н хүрээнд, Ургамлын физиологийн лабораторийг БСШУЯам, Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй хэрэгжсэн “Багш бэлтгэх сургуулиудын орчин нөхцөлийг сайжруулах төсөл”-ийн санхүүжилтээр, нийт 5 лабораторийг тоногложээ.

Анхаарах асуудал:

- Багш, байгалийн ухааны боловсрол хөтөлбөр нь Биологийн тэнхимд харьяалагдах бөгөөд орлого, зардлын баримт тайлан БУС-ийн хэмжээнд бусад тэнхимтэй хамт байгаа нь тус хөтөлбөрийн санхүүжилтийг тайлагнахад хангалттай бус байгааг анхаарах

Зөвлөмж:

- Цаашдаа төсөл хөтөлбөр, өөрийн үйл ажиллагаагаар өөрөө өөрийгөө санхүүжүүлэх талаар хууль эрхзүйн болон бусад холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах боломж байгаа эсэхийг судлах.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын хөтөлбөр, мэргэжил, төгсөгчдийн ажил эрхлэлттэй холбогдох асуудлаар санал асуулга, судалгаа авдаг.
- Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлтийн хүрээнд хөтөлбөр, мэргэжлээ сурталчлах өдөрлөг арга хэмжээг хичээлийн жилийн намар, хаврын улиралд тогтмол зохион байгуулдаг. Тухайлбал, оюутан залууст “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ”, “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ”, “Ирээдүйн чиг хандлагыг ойлгох” зэрэг цуврал уулзалт, ярилцлагыг явуулж зөвлөгөө өгч ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2019 онд Биологийн тэнхимээс “Ажил олгогчдын уулзалт” зохион байгуулж, төгсөгчдийн очиж ажилладаг 20 гаруй байгууллагын төлөөллийг хамруулсан.
- Жил бүр мэргэжлийн хөтөлбөрүүдийн товч мэдээллийг ЕБС-ийн төгсөх ангийн сурагчид болон эцэг, эхчүүдэд хэвлэмэл материал, видео танилцуулга байдлаар элсэлтийн сурталчилгааг хийсэн байна.
- 2021 оноос МУИС-д байгалийн ухааны чиглэлээр суралцаж буй оюутнуудад тэтгэлэг олгох ажлыг зохион байгуулж эхэлсэн байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдын тоо, хөтөлбөр сонгогчдын тоо нэмэгдээгүй байгааг анхаарах

Зөвлөмж:

- Маркетингийн идэвхжүүлэлтийн үр дүнг тооцох, шинэлэг аргууд хэрэгжүүлж, идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулах

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС нь албан ёсны эх сурвалж болох вэб сайтаараа дамжуулан сургуулийн олон талт үйл ажиллагааны талаар өргөн хүрээний мэдээллийг олон нийтэд түгээдэг.
- МУИС-ийн багш, суралцагчдад сургалтын удирдлага, мэдээллийн SiSi систем <http://sisi.num.edu.mn-ээп> дэлгэрэнгүй мэдээллийг хүргэж, тогтмол шинэчлэн ажилладаг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Вэб нь бүтцийн хувьд Бидний тухай, Элсэлт, Сургалт, Судалгаа, хамтын ажиллагаа, Сургуулийн орчин, Хөрөнгө оруулалт, Шилэн данс, Холбоо барих гэсэн үндсэн цэсүүдийг агуулах бөгөөд эдгээрээс гадна Хөтөлбөр, Багш ажилчид, Оюутан, Төгсөгчид, Ажлын байр гэсэн цэсүүдтэй. Эдгээр цэс рүү хандсанаар тухайн агуулгын дэлгэрэнгүй мэдээллүүдийг агуулсан дэд цэс руу шилжих боломжтой.
- Биологийн тэнхимийн цахим хуудас (<http://dep.num.edu.mn/biology>) -аар дамжуулан тухайн хөтөлбөрүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг байршуулж суралцагчдад нээлттэй хүргэж байна.
- Биологийн тэнхимийн вэбсайтаас гадна Хөтөлбөрийн дэлгэрэнгүй танилцуулга бүхий вэб хуудастай. https://hutulbur.num.edu.mn/publ/php/program_detail.php?pid=5

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс нийгэмд чиглэсэн үйл ажиллагаанд багш оюутныг татан оролцуулах хөтөлбөр арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Тухайн тэнхим бүрэлдэхүүн сургуулийн веб хуудсаар зочлогчдын тоон үзүүлэлт дээр хөтөлбөр хэрэгжүүлэгч баг хяналт тавих. Мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэх

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

Биологийн тэнхим Дээд боловсролын тухай хууль, БШУЯ-ны сайдын А/79 тоот тушаал, мөн МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт оюутан элсүүлэх журам мөрдөн оюутан элсүүлж байна.

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС нь ББУБ хөтөлбөрт оюутан элсүүлж авахдаа МУ-ын холбогдох хууль, журмыг дагаж мөрдөж байна. Энэ нь тухайн хөтөлбөрт элсэж буй оюутнуудыг мэдээллийн нэг эх сурвалжтай байх, элдэв эргэлзээгүй элсэн ороход нь дөхөм болж байна.
- Элсэгчдийн дундаж ЭЕШ оноо нь 607 , босго онооноос даруй 200 хүртэлх оноогоор илүү байна.
- ЕБС төгсөн МУИС-ийн оюутан болж буй шинэ оюутнуудад чиглэсэн чиглүүлэх сургалтыг алба нэгжүүд, мэргэжлийн тэнхим хамтран зохион байгуулж байна.

Анхаарах асуудал:

- ББУБ хөтөлбөрт элсэгчдийн тоо оюутан элсүүлэх квотоос бага байгааг анхаарах.
- Мэргэжил сурталчлах үйл ажиллагааг өргөн цар хүрээтэй зохион байгуулахад анхаарах.
- Чиглүүлэх сургалтад хөтөлбөрт элсэн суралцагчдыг бүрэн хамруулахад анхаарах.

Шаардлага:

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлж элсэлтийн үйл ажиллагаанд хамтран ажиллах
- Мэргэжлийн онцлог, төгсөгчдийн карьер өсөлтийн талаар сурталчлах зэрэг маркетингийг идэвхжүүлж элсэлтийг нэмэгдүүлэх

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарыг зөвлөх багшаар ажиллуулах тухай журмын дагуу сургалтын журмын 4.5.3, 4.5.26-д заасны дагуу зөвлөх багшийг томилон ажиллуулж байна.
- Оюутан төгсөгчийн хэлтсээс ажил олгогчийн, төгсөгчийн болон суралцагчдын дунд сэтгэл ханамжийн асуулга судалгааг авч, эмхэтгэн ном болгон хэвлэж байна.
- Боловсрол судлал, биологийн мэргэжлийн чиглэлээр зохиогддог эрдэм шинжилгээний хуралд оюутнуудад зөвлөн, оролцох боломжоор хангадаг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн ББУБ хөтөлбөрт суралцаж буй оюутнуудад үзүүлж буй мэдээлэл технологийн, сэтгэл зүйчийн, эмнэлгийн, сургалтын албаны болон номын сангийн үйлчилгээ үзүүлдэг.
- МУИС-ийн Биологийн тэнхимийн багш нар ББУБ хөтөлбөрт суралцаж буй оюутнуудыг олон улсын болон дотоодын төсөлд хамрагдах боломж бололцоогоор ханган ажилладаг.
- Боловсрол судлалаар сүүлийн 5 жилд 15 оюутан, биологийн чиглэлээр 5 оюутан оролцсон байна.

- ББУБ хөтөлбөрийн оюутнууд МУИС-ийн нэрэмжит болон гадаад, дотоодын сангийн нэрэмжит нэр бүхий 15 тэтгэлэгт хамрагдах боломжоор хангагджээ.
- 2016 оноос хойш 5 оюутан төсөл хөтөлбөрт хамрагдаж, 4 оюутан тэтгэлэг авсан байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчдыг оюутан солилцооны болон төсөл хөтөлбөрүүдэд хамруулах боломжийг эрэлхийлэхэд анхаарах

Зөвлөмж:

- Нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд багш суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх
- Суралцах явцдаа хөдөлмөр эрхлэх боломж нөхцлийг бүрдүүлэх

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- ББУБ оюутнуудын 18% нь хамрагдсан байна
- МУИС-ийн захирлын А/571 тоот тушаалаар батлагдсан “МУИС-д суралцагчдад тэтгэлэг олгох журам” батлагдан мөрдөн ажиллаж байна.
- Мэргэжил сурталчлах өдөрлөгт ББУБ хөтөлбөрт суралцаж буй оюутнууд идэвхтэй оролцдог байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш болох оюутнуудын дунд “Багшлах ур чадварын тэмцээн” зохиогддог бөгөөд 4 жилийн хугацаанд нийт 40 орчим оюутан оролцсон нь ББУБ хөтөлбөрийн дийлэнх хувь нь байна.

Анхаарах асуудал:

- Чиглүүлэх сургалтын явцад олон нийтийн клубийн үйл ажиллагаа болон, төсөл хөтөлбөр, тэтгэлгийн талаар сайтар танилцуулж, цаашид тэтгэлэг авсан, төсөлд оролцсон оюутны тоог нэмэгдүүлэх.

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн захирлын А/483 тоот тушаалаар батлагдсан “МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам”
- Гадаадын их, дээд сургуулиас шилжин суралцах, дотоодын их сургуулиас шилжин суралцах мөн хөтөлбөр хооронд шилжин суралцах үед гарах багц цагийг дүйцүүлэн тооцох арга, аргачлал, шаардлага зэргийг тусгасан журмын заалтууд
- 2016 оноос хойш нийт 3 суралцагч МУИС-ийн өөр хөтөлбөрөөс ББУБ хөтөлбөрт шилжин ирж суралцсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-ийн Биологийн тэнхимийн ББУБ хөтөлбөрт суралцаж буй оюутнууд гадагш шилжээгүй харин гурван оюутан тус хөтөлбөрт шилжин ирсэн нь уг хөтөлбөрийн чанар, хэрэгцээг илтгэж байна.
- Шилжилт хөдөлгөөн явуулах, шаардлага зэргийг МУИС журмаараа нарийн чанд тогтоосон байна.
- Багц цагийн дүйцүүлэх журам батлагдаж тухайн журмын дагуу холбогдох тэнхим, бүртгэл хариуцсан мэргэжилтэн зэрэг хариуцлага бүхий албан тушаалтан багц цагийн дүйцүүлэх үйл ажиллагааг явуулдаг нь давуу тал.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- “МУИС-ийн сургалтын журам”-ын холбогдох заалтын дагуу төгсөлтийг зохион байгуулж, баримт бичгийг олгодог.
- Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан
- 2020 оны төгсөгчийн төгсөлтийн баримт бичгийн (дипломын) хуулбар

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2018-2022 оны хооронд тус хөтөлбөрөөр нийт 36 оюутан төгссөн байна.
- Жилд 2 удаа буюу хавар, намар төгсөлтийг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Төгсөлтийн баримт бичигт чөлөөт сонголтын хэсэгт багц цагийг зөрүүтэй тэмдэглэсэн.

Зөвлөмж:

- Сургалтын төлөвлөгөөнд тусгасан багц цагийн дагуу төгсөлтийн бичиг баримтад тэмдэглэгээ хийх

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш, байгалийн ухааны боловсрол бакалаврын хөтөлбөрт багшлах бүрэлдэхүүний нөөц бүрдсэн.
- “МУИС-д профессор, багш ажиллуулах журам”, “МУИС-ийн профессор, багшид тавигдах шаардлага”, “МУИС-д шинээр багш авах”, “Зөвлөх, гэрээт ба зочин професоор цагийн багшаар ажиллуулах” журмыг баримтлан хөтөлбөрт багшийг шинээр сонгон шалгаруулж авдаг.
- Хөтөлбөрийн багш нарын албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг МУИС-ийн Захирлын 2014 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/414 дугаар тушаал буюу МУИС-д “Профессор, багш ажиллуулах журам”-ын 8 дугаар заалтын дагуу мөрдлөг болгон

явуулдаг. Уг заалтын дагуу багш нар албан тушаалын аль зэрэглэл дээр ажиллах хүсэлтээ өөрсдөө гаргаж шаардагдах тайлан, нотолгоог бэлдэж МУИС-ийн болон салбар сургуулийн захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт хүргүүлдэг. Ажлын хэсэг багш тухайн зэрэглэлд ажиллах боломжтой эсэхэд хариу дүгнэлтийг өгч, МУИС-ийн захирлын тушаал гарч баталгааждаг. Энэ процесс гурван жил тутамд нэг удаа явагдаж албан тушаалын зэрэглэл ахих, буурах, хэвэндээ үлдэх асуудлыг шийдвэрлэдэг.

- Багш, байгалийн ухааны боловсрол хөтөлбөрт 2018 онд 17, 2019 онд 23, 2020 онд 13 оюутан сонгон суралцаж байгаа бөгөөд тайлант хугацаанд багш оюутны харьцаа ойролцоогоор 1:1.7 байна.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа багш нарыг чанарын болон гүйцэтгэлийн үнэлгээнд суурилан урамшуулдаг. Хичээлийн жил бүрийн эхэнд багш нарын өнгөрсөн хичээлийн жилийн гүйцэтгэлийг дүгнэж, цалингийн тодорхой хувьтай тэнцэх мөнгөн дүнгээр урамшуулалт цалин олгодог.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Үндсэн хөтөлбөрт хичээлийн жилд дунджаар 20 багш ажилладаг ба 14 нь буюу 70% нь докторын зэрэгтэй бөгөөд үүнээс 1 нь зөвлөх профессор, 4 нь профессор, 7 нь дэд профессор, 5 нь ахлах багш, 6 нь багш, 1 нь дадлагажигч багшийн албан тушаалын зэрэглэлээр ажиллаж байна.
- Хөтөлбөрт ажиллаж буй багш нарыг эрдмийн цол, зэргээр нь авч үзвэл 20.0% доктор, профессор, 35.0% нь доктор, дэд профессор, 10.0% нь доктор, 30.0% нь магистр зэрэгтэй байна.
- Хөтөлбөрт 2017 онд 3, 2020 онд 1 багшийг сонгон шалгаруулж авч ажиллуулсан.
- Биологийн хөтөлбөрөөс нийт 18 багш, ажилтан төрийн дээд одон медаль, засгийн газрын шагнал, салбарын тэргүүн, яамны жуух болон бусад шагналаар шагнагдсан байна. 2016-2021 онд Алтан гадас одонгоор 4, Хөдөлмөрийн хүндэт медаль 3, салбарын тэргүүний ажилтнаар 4, жуух бичиг 2, МУИС-ийн шилдэг судлаач 1, бусад шагналаар (давхардсан тоогоор) тус тус шагнагджээ.
- Энэ хугацаанд хөтөлбөрийн 14 (давхардсан тоогоор) багш Web of Science, Scopus бүртгэлтэй сэтгүүлд 38 өгүүлэлийг хэвлүүлж урамшуулалд хамрагдсан.
- Тус хөтөлбөрийн багш нараас албан тушаалын зэрэглэлийг тогтоох ажлын хүрээнд багш нарын зэрэглэлийн болзол хангаж ахлах багшид 2, багшид 1 багш зэрэг дэвшин ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Багш, суралцагчийн тооны зохистой харьцаа алдагдсан байгааг анхаарах. Цаашид энэ тоог нэмэгдүүлэх талаар элсэлтийн бодлогод тусгаж 1:11-12 болгох.

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн захирлын 2019 оны 02-р сарын 04-ний өдрийн А/52 тоот тушаалаар батлагдсан “Багшийн хөгжлийн хөтөлбөр 2019-2024” бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.
- “Багшийн хөгжил, цахим сургалтын төв” нь багшийн мэргэжил, заах арга зүйн ур чадвар, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин, суралцах хэрэгцээг тодорхойлох чиглэлээр тус бүр 5 төрлийн судалгаа, сургалт, хөтөлбөрүүдийг жил бүр тогтмол зохион байгуулдаг.
- МУИС-ийн профессор, багш ажиллуулах журмын дагуу жил бүрийн А, Б, В, цагийн гүйцэтгэл, өөрийн үнэлгээний тайлан, аттестатчиллын журмын дагуу үнэлж цагийн гүйцэтгэлийг тооцохын зэрэгцээ хувь хүний ахиц дэвшил, тухайн багшийн хөгжлийн түвшинг тогтоох нэг үндэслэл нь болдог байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- МУИС-д багшийн академик хөгжлийн хөтөлбөрт багш нарын академик хэрэгцээний тандалт судалгааны үр дүнг тусгасан, мэргэшсэн сургагч багшаар ажиллах багш нарын мэдээллийн сан нээсэн, онлайн студи байгуулах, багш нар МООС-д хичээлээ байршуулах бодит боломж бүрдсэн мөн дижитал профессорын студийг байгуулснаар профессор багш нарын хичээлийн онлайн контентыг бичих, байршуулах, улмаар ярилцлага, аман түүх бичих, ахмад багш нарын оюуны өвийг бичиж үлдээх зэрэг боломжууд бий болсон.
- 2016-2021 онд “Багшийн хөгжил, цахим сургалтын төв”-ийн сургалтад 19, гадаадын мэргэжил нэгт эрдэмтэд болон гадаадын судалгааны хүрээлэн, лабораториудад 15, орон нутагт 8, бусад сургалтад 10 гаруй багш (давхардсан тоогоор) хамрагджээ. Тухайлбал, багш, байгалийн ухааны хөтөлбөрөөс:
 - ✓ Academic English – Research Paper Writing сургалтад -3 багш
 - ✓ New Faculty Orientation сургалтад –1 багш
 - ✓ Faculty writing retreats сургалтад – 2 багш
 - ✓ Effective Teaching In Higher Education programs сургалтад -5 багш
 - ✓ Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын эшлэл зүүлт, ном зүйг электрон программ ашиглан бичих (Mendeley Reference Management System) сургалтад – 3 багш
 - ✓ “Recognition and transfer of Credit Allocation and Grading Systems” сургалтад – 2 багш
 - ✓ “Судалгааны өгүүлэл бичих арга зүй” сургалтад -1 багш
 - ✓ “Онлайн сургалтын орчин, агуулга хөгжүүлэх арга зүй” сургалтад -8 багш
 хамрагдаж, хөтөлбөрийн хөгжилд түлхэц болохуйц мэдлэг, мэдээллээс суралцжээ.
- Цаг үеийн нөхцөл байдлын улмаас цахим сургалтад шилжсэнээр хөтөлбөрийн багш нарын онлайн хичээл бэлтгэх, заах чадвар ахисан байна.

Анхаарах асуудал:

- Гадаадын их дээд сургууль болон мэргэжлийн байгууллагуудтай багш солилцооны хөтөлбөрт тус хөтөлбөрийн багш нараас хамруулахад илүү анхаарах
- Тус хөтөлбөрийн профессор, багш нараас МУИС-ийн хэмжээнд байгуулсан багш нарын мэдээллийн сан, онлайн студи, дижитал профессорын студи зэрэг үйл ажиллагаанд тайлангийн хугацаанд хамрагдаагүй байгааг анхаарах
- Цаашид хөтөлбөрийг багш нарын заасан хичээлийн онлайн контентыг бичих, байршуулах, улмаар ярилцлага, аман түүх бичих, ахмад багш нарын оюуны өвийг бичиж үлдээх зэрэг үйл ажиллагаанд хамруулах

Зөвлөмж:

- Багш нарын хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалт, судалгааг багш нараас авсан санал дээр үндэслэн зохион байгуулах
- Багш нарыг мэргэжил дээшлүүлэх, сургалтад хамрагдахад сургуулийн зүгээс төсвийн тодорхой хувийг зарцуулдаг болох

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- Биологи хөтөлбөрийн багш нар 2014-2020 онд эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр гадаадад 236 өгүүлэл хэвлүүлсний 130-ийг олон улсын IF-тэй сэтгүүлд, дотоодод 184 өгүүлэл хэвлүүлсний 44 нь англи хэл дээр бичигджээ. Түүнчлэн 11 сурах бичиг, 86 сургалтын гарын авлага, 22 орчуулгын бүтээлийг хэвлэн нийтлүүлж, сургалтад ашиглаж байна.
- Тэнхимийн багш нар улсын захиалгат, олон улсын хэмжээний шинжлэх ухаан технологийн болон суурь судалгааны төсөл боловсруулж хэрэгжүүлдэг.
- Сүүлийн жилүүдэд багш нараас БСШУЯ-ны ШУТС, МУИС (Старт ап), БОАЖЯ болон WWF-монгол дахь салбар зэрэг байгууллагын дотоодын санжүүжилттэй 12 төсөл, гадаадын санхүүгийн дэмжлэгтэй хамтарсан 24 төсөл, хөтөлбөрүүдэд ажиллаж байна.
- МУИС-ийн зүгээс багш нарын судалгааны үр дүн, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах, салбар дундын судалгаанд багш, оюутны хамтын оролцоог идэвхжүүлэх, гарааны компани байгуулахад дэмжлэг үзүүлэх зорилготой багш, оюутны “Старт ап” хөтөлбөр хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрт “Багш, байгалийн ухааны боловсрол” хөтөлбөрийн 3 багш хамрагдаж, гарааны компанийн шалгаруулалтад оролцжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017-2021 оны байдлаар Багш, байгалийн ухааны боловсрол бакалаврын хөтөлбөрт ажилласан багш нар судалгааны ажлын үр дүнгээр олон улсын мэргэжлийн сэтгүүлд нийтдээ 130 бүтээлийг хэвлүүлжээ. Үүнийг ангилан үзвэл:
 - ✓ Web of Science-д бүртгэлтэй IF-гүй олон улсын редакцын зөвлөл бүхий реер-reviewed олон улсын сэтгүүл, хурлын эмхэтгэлд 32 өгүүлэл
 - ✓ IF 0-1.499 бүхий олон улсын сэтгүүлд 38 өгүүлэл
 - ✓ IF 1.5-3.0 бүхий олон улсын сэтгүүлд 43 өгүүлэл
 - ✓ IF 3.001-5.0 бүхий олон улсын сэтгүүлд 12 өгүүлэл
 - ✓ IF 5.01-ээс дээш олон улсын сэтгүүлд 5 өгүүлэл
- Тус хөтөлбөрт багшилж байгаа багш нарын эрдэм шинжилгээний бүтээлээс бусад судлаачдын эш татсан тоо ба h индекс (Hirsch's index) -г тодруулвал 2017-2021 онд 30-аас дээш удаа эшлэгдсэн үзүүлэлттэй байна.
- Энэ хугацаанд багш нарын бүтээлийг инновац болгох, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх талаар Биологийн тэнхимийн багш нар эрдэм шинжилгээний ажлын үр дүнгээр нийт 8 бүтээл батлуулжээ. Үүнээс багш, байгалийн ухааны боловсрол хөтөлбөрийн хүрээнд:
 - ✓ “SARS-COV-2 эсрэг бие илрүүлэх фермент холбоот урвалын оношлуур, түүнийг бэлтгэх арга”. Шинэ бүтээлийн патент
 - ✓ “Хуурайшилт, давсжилтад тэсвэртэй ургамлын үрийн сонголт хийх арга”. Шинэ бүтээлийн патент
 - ✓ “Цаасыг дахин боловсруулахдаа ургамлын үрээр баяжуулах арга”. Ашигтай загвар

- ✓ Хонь, ямааны мах болон цусны гарал үүслийг ялгах поликлонт эсрэг биет түргэн оношлуур”. Ашигтай загвар
- ✓ Хөрсөнд явагдаж байгаа биологийн процессын эрчмийг тодорхойлох арга”. Шинэ бүтээлийн патент зэрэг бүтээл тус тус бүртгэгдсэн байна.
- Жил бүр их сургуулийн эрдэмтэн судлаачдын бүтээл туурвих, шинийг санаачлах үйл ажиллагааг дэмжиж, инновацын соёлыг төлөвшүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор “МУИС-ийн Шилдэг оюуны өмч бүтээгч”-ийн шалгаруулалтыг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн багш нарын судалгааны ажлын үр дүнг инновац, ашигтай загвар, зохиогчийн эрх, патентаар баталгаажуулах, тоог нэмэгдүүлэх
- Багш нарын хэвлүүлсэн бүтээлийн эшлэгдсэн байдлын талаар тоон мэдээлэл гаргах

Зөвлөмж:

- Эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг сургалтын болон мэргэжлийн байгууллагуудад таниулах, сурталчлах

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- “МУИС-д профессор багш ажиллуулах журам”-ын дагуу багшийг сургалт, заах арга зүйд оюутны үнэлгээ, комиссын үнэлгээ, удирдлагын үнэлгээ гэсэн чиглэлээр дүгнэнэ. Эрдэм шинжилгээ, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээнд комиссын болон удирдлагын үнэлгээ багтдаг.
- Хичээлийн жилийн эхэнд өмнөх хичээлийн жилийн багшийн ажлын нэгдсэн дүнг үнэлэх бөгөөд жил бүр хичээлийн жилийн төгсгөлд багш нарын сургалтын ажлын гүйцэтгэлийг тэнхимийн эрхлэгч тооцож сургалт хариуцсан нэгж хянах ба багш нарын жилийн нийт А, Б, В цагийн гүйцэтгэлийг бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал хянан баталгаажуулна.
- Багш нарын ажлын гүйцэтгэлд урамшуулалт цалин тооцохдоо дараагийн жилийн эхэнд өмнөх хичээлийн жилийн А, Б, В цагийн гүйцэтгэл дээр тухайн хичээл орсон багшид оюутнуудын өгсөн үнэлгээ (SiSi системээр дамжуулан авдаг) болон багшийг хамт ажиллагчдын үнэлгээ зэргийг нэмэн үнэлдэг.
- Биологи, байгалийн ухааны боловсролын мэргэжилтэн бэлтгэдэг багш нар ажлын нэгдсэн үнэлгээний дүнгээр жил бүр дунджаар 90-ээс дээш хувьтай үнэлэгдсэн байна.
- МУИС-ийн багшийн үнэлгээний нэгдсэн журам (аттестачлал)-д заасны дагуу тухайн тэнхимийн багш нар заагдсан хугацаандаа аттестатчилалд хамрагдаж байснаас гадна бүх багш нараас хичээл орсон оюутнуудаар СИСИ мэдээллийн системээр дамжуулан судалгаа авч ирсэн нь энэ талаар багшийг хөндлөнгөөс үнэлэх нөгөө талаас багш сайн үнэлэгдэхийн тулд чанартай сургалт явуулах нэг нөхцөл болж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, бусад ажил гэсэн чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол өгч, үр дүнг тооцдог.
- Багш нар судалгааны ажлын үр дүнгээр өөрийн заадаг хичээлийн агуулга, арга зүй, судалгааны ажлыг шинэчлэн сайжруулдаг.
- 2016-2021 онд хөтөлбөрийн 5 багш аттестатчилалд хамрагдаж, амжилттай үнэлэгдсэн байна.

Анхаарах асуудал:

- Багш нарыг “Суралцагчдын харилцаа, хандлагыг хөгжүүлэх, заах арга зүйн чиглэлийн чадавхжуулах” сургалтуудад хамруулах

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хариуцсан нэгж 2017 оноос Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба нэртэйгээр, 2018 оноос Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын хэлтэс нэртэйгээр үйл ажиллагаа явуулж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилладаг.
- Сургалтын чанарын тогтолцооны зураглал.
- Чанарын дотоод баталгаажуулалтын хэлтсийн ажлын төлөвлөгөө
- Хөтөлбөрийн хороодын зохион байгуулалт, хуралдааны тэмдэглэлүүд

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**Онцлог зүйл/Туршлага:**

- Биологийн тэнхимийн хөтөлбөрийн дэд хороонд хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын төлөөлөл ажилладаг

Анхаарах асуудал:

- Чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон бодлого, журам, хөтөлбөр, боловсруулахад анхаарах
- Чанарын дотоод баталгаажуулалтын гарын авлагын боловсруулахад тэнхэмийн хөтөлбөрийн дэд хорооны гишүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах

Шаардлага:

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч баг төгсөгчидтэйгөө эргэх холбоотой байж, 5 жил тутамд эрэлт хэрэгцээг тандан судалж, хөтөлбөрийн хөгжүүлэлт хийж хэвших
- Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын журам баталж, гарын авлага боловсруулах
- Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ гаргах

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Илрэл нотолгоо:

- МУИС-ийн суралцагчийн төгсөгч, ажил олгогчдоос сэтгэл ханамжийн судалгаа авч дүн шинжилгээ хийсэн

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017-2020 оны нийт төгсөгчдийн тоо 2014-2022оны хооронд 101 сүүлийн 5 жилд 36 төгсөгчтэй
- Төгсөгчдийн судалгаанаас харахад 2017-2020 оны төгсөгчдийн 84.6 % ажил эрхэлж,76.9% нь мэргэжлээрээ ажил эрхэлж байгаа бол 15.4% нь ажил эрхлээгүй байна
- Төгсөгчдийн ажлын байраар хангагдах хүртэлх хүлээх хугацаа 5,3 сар
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаанаас 2017-2020 оны төгсөгчдийн 84.6 % ажил эрхэлж,76.9% нь мэргэжлээрээ ажил эрхэлж байгаа бол 15.4% нь ажил эрхлээгүй байна
- Төгсөгчдийн мэргэжлийн мэдлэг чадвар 70%, бичих ур чадвар 60%, ярианы ур чадвар 60%, компьютер интернет ашиглах чадвар 60% маш сайн байгаа бол бизнес эрхлэх чадвар 33% муу олгосон гэж үзжээ.
- Ажил олгогчдын зүгээс төгсөгчдийн мэдлэг ур чадварын талаар 57.1% маш сайн, 42.9% сайн ажил олгогчийн шаардлагад ихэвчлэн болон бүрэн нийцдэг гэж үзсэн байна. Судалгаанд УБ хотын 6 сургууль, хөдөө орон нутгийн 2 сургуулийн сургалтын менежер хамрагдсан байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгаа хийх
- Хөтөлбөрийн үр дүнгийн судалгааг ямар аргачлалаар хэрхэн зохион байгуулдаг талаар мэдээлэл дутмаг
- Сэтгэл ханамжийн судалгааны үр дүнд шинжилгээ хийж, үр дүнг үйл ажиллагаандаа тусгах

Зөвлөмж:

- Төгсөгчдийн карьер өсөлтийн судалгааг авч алдаршуулах, хөтөлбөрийн маркетингт ашиглах
- Тус хөтөлбөрийн оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгаа, дүн шинжилгээг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУИС нь 2018 онд 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн
- ШУС-ийн Биологийн тэнхимийн танилцуулга

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

Дараагийн шатны хөтөлбөрт дотоодод 1докторант, 2магистрант;гадаадад 1 докторант (Солонгос), 2 магистрант (Хятад) үргэлжлүүлэн суралцаж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа хийх

- Ажил олгогч байгууллагуудтай хамтран ажилласан ажлын тайлан мэдээнд дүн шинжилгээ хийх

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа хийх
- Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

ДҮГНЭЛТ

Байгууллагын нэр: Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны их сургууль

Хөтөлбөрийн нэр: Багш, Байгалийн ухааны боловсрол (Биологи)


Индекс: D011402

Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2	1	1.2
2	Сургалтын үйл	1	2	2.1;2.2
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн	3		
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5		
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5	1	5.1
6	Багшийн үйл ажиллагаа	4		
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2	1	7.1;
		21	5	
Дүгнэлт	Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны их сургуулийн сургуулийн “Багш, Байгалийн ухааны боловсрол (Биологи)” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг “Боловсрол”-ын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг У.Мягмаржав
 Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг М.Бүрнээ
 Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг Г.Онолрагчаа



НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Монгол Улсын Их Сургууль, Шинжлэх ухааны их сургууль
Хөтөлбөрийн нэр	Багш, Байгалийн ухааны боловсрол (Биологи)
Хөтөлбөрийн индекс	D011402
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгүүдэд тодорхойлох - Хөтөлбөрийн зорилт, хөтөлбөрийн болон хичээлийн суралцахуйн үр дүнг тодорхойлох - Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг чадвар ба хөтөлбөрийн зорилго зорилтуудын хоорондын уялдаа холбоо хамаарлыг (матриц) хийх
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Сургалтын төлөвлөгөөний бүтцийг сайжруулах, Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын саналыг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах, сургалтын арга зүйг хичээлийн хөтөлбөрт тусгах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> - Суралцагчид чиглэсэн хоолны газрын үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх - Сургуулийн номын санд нэвтэрсэн цахим мэдээллийн санг сургалтдаа ашиглах
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - Маркетингийн идэвхжүүлэлтийн үр дүнг тооцох, шинэлэг аргууд хэрэгжүүлж, идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг сайжруулах
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> - ББУБ хөтөлбөрт элсэгчдийн тоо оюутан элсүүлэх квотоос бага байгааг анхаарах. - Нийгэмд чиглэсэн сайн дурын үйл ажиллагаанд багш суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх - Суралцах явцдаа хөдөлмөр эрхлэх боломж нөхцлийг бүрдүүлэх - Сургалтын төлөвлөгөөнд тусгасан багц цагийн дагуу төгсөлтийн бичиг баримтад тэмдэглэгээ хийх
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг сургалтын болон мэргэжлийн байгууллагуудад таниулах, сурталчлах - Багш нарыг “Суралцагчдын харилцаа, хандлагыг хөгжүүлэх болоод заах арга зүйн чиглэлийн чадавхижуулах” сургалтуудад хамруулах

<p>Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт</p>	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөр хэрэгжүүлэгч баг хөтөлбөрийн чанарын баталгаажилтын хангах чиглэлийн ажлыг төлөвлөж хэрэгжүүлж хянаж үнэлж дүгнэх - Хөтөлбөрөөр төгсөгчдийг мэргэжлийн салбарт хүлээн зөвшөөрснийг нотлох баримт бичгийн судалгаа хийх - Мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах ажлын төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх
<p>ШААРДЛАГА Хэсэгчлэн хангасан юм уу хангаагүй гэсэн дүгнэлт өгсөн шалгуур, дэд шаардлага бүрд заавал шаардлага бичнэ.</p>	
<p>Шалгуур 1.2</p>	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн зорилтыг томъеолж, суралцахуйн үр дүнг боловсруулах - Хөтөлбөрийн зорилгын өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлж, оролцогч талуудыг саналыг тусган сайжруулах үйл ажиллагааг тогтмолжуулах
<p>Шалгуур 2.1</p>	<ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөрийн бүтэц дэхь ерөнхий суурь чиглэл (А), Мэргэжлийн суурь чиглэл (Б), Мэргэжлийн чиглэл (В)-ийг тус бүрт нь заавал болон сонгон судлах гэсэн 2 хэсэгтэйгээр төлөвлөх - Сургалтын төлөвлөгөөний бүтцийг сайжруулж, ерөнхий суурь хичээлийн төлөвлөлтөд судлагдахууны чиглэлийг бус, хичээлийн нэр багц цагийг тодорхой тусгах - Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын саналыг хөтөлбөрийн сайжруулалтад ашиглах - Хичээлийн хөтөлбөрийн (CLO) суралцахуйн үр дүнг тодорхойлох - Сургалтын төлөвлөгөөний Б2,В2 сонголтоос хийсэн хичээлийн багц цагийг Чөлөөт сонголтын 15 багц цагт багтаан дипломын бичилтэд тооцон бичдэг байх - Хөтөлбөрийн хичээлүүдийн залгамж холбоог сайжруулан зураглах
<p>Шалгуур 2.2</p>	<ul style="list-style-type: none"> - Сургалтын арга зүйн судалгааг хийж үр дүнг хөтөлбөрийн сайжруултад ашиглах;
<p>Шалгуур 5.1</p>	<ul style="list-style-type: none"> - Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг идэвхжүүлж элсэлтийн үйл ажиллагаанд хамтран ажиллах; - Мэргэжлийн онцлог, төгсөгчдийн карьер өсөлтийн талаар сурталчлах зэрэг маркетингийг идэвхжүүлж элсэлтийг нэмэгдүүлэх;
<p>Шалгуур 7.1</p>	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөр хэрэгжүүлэгч баг төгсөгчидтэйгөө эргэх холбоотой байж, 5 жил тутамд эрэлт хэрэгцээг тандан судалж, хөтөлбөрийн хөгжүүлэлт хийж хэвших - Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын журам баталж, гарын авлага боловсруулах - Хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр хийсэн ажлын тайлан мэдээ гаргах

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Заадаг хичээл
1.	Б. Баяртогтох	Профессор	Профессор, Доктор (Sc.D.)	Амьтны биологи
2.	С. Гомбобаатар	Профессор	Дэд профессор, Доктор (Ph.D.)	Эволюцийн биологи, Хөгжлийн биологи
3.	Н. Сонинхишиг	Профессор	Дэд профессор, Доктор (Ph.D.)	Ургамлын биологи, Хөгжлийн биологи
4.	Б.Батжаргал	Профессор	Дэд профессор, Доктор (Ph.D.)	Биохими 1
5.	Б. Оюунцэцэг	Профессор	Дэд профессор, Доктор (Ph.D.)	Ургамлын биологи
6.	Д. Нямбаяр	Дэд профессор	Дэд профессор, Доктор (Ph.D.)	Ургамлын биологи
7.	Д. Түмэнжаргал	Зөвлөх дэд профессор	Дэд профессор, Доктор (Ph.D.)	Микробиологи
8.	Ж. Хулан	Профессор	Дэд профессор, Доктор (Ph.D.)	Генетик
9.	Ш. Оюунгэрэл	Дэд профессор	Дэд профессор, Доктор (Ph.D.)	Ургамлын физиологи, Биологид хичээлийн хөтөлбөр, арга зүй (X-XII), Сурган хүмүүмүүлэх дадлага-2
10.	У. Айбек	Дэд профессор	Дэд профессор, Доктор (Ph.D.)	Экологийн үндэс
11.	Д. Оюунцэцэг	Ахлах багш	Магистр (M.Sc.)	Генетик
12.	Т. Сувдмаа	Ахлах багш	Доктор (Ph.D.)	Биохими 1
13.	Ч. Баттулга	Ахлах багш	Магистр (M.Sc.)	Биологийн сургалтын онол, арга зүй, Сурган хүмүүжүүлэх танилцах дадлага, Сурган хүмүүмүүлэх дадлага-1
14.	П. Жаргалсайхан	Багш	Магистр (M.Sc.)	Амьтны биологи Хүний биеийн анатоми физиологи
15.	Д. Нарантуяа	Багш	Магистр (M.Sc.)	Микробиологи
16.	Ч. Оюундарь	Багш	Магистр (M.Sc.)	Ургамлын биологи

17.	М. Хонгорзул	Багш	Магистр (M.Sc.)	Биохими 1
-----	--------------	------	-----------------	-----------

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Заадаг хичээл
1	Б.Золзаяа /99039110/	Багш	Магистр (M.Sc)	Ерөнхий сэтгэл судлал
2	Б.Болдсүрэн /99245404/	Багш	Магистр (M.Sc)	Сурган хүмүүжүүлэх зүй
3	М.Дэлгэржав/99992229/	профессор	Дэд профессор, Доктор (Ph.D)	Сурган хүмүүжүүлэх сэтгэл судлал
4	Б.Болдсүрэн	Багш	Магистр (M.Sc)	Сургалтын технологи
5	Ж.Даваа /99255594/	Зөвлөх профессор	Профессор, Доктор (Ph.D)	Багшийн ёс зүй
6	Б.Болдсүрэн	Багш	Магистр (M.Sc)	Хүүхэд судлах арга зүй

II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	E-mail.address, Утас
1	Ц.Үржинлхам	4-р түвшин	17B1NUM1011@stud.num.edu.mn uka4304@yahoo.com 95854304
2	Б.Бадам	4-р түвшин	17B1NUM3136@stud.num.edu.mn , badam.ariunaa@yahoo.com , badam.ariunaa@yahoo.com 86280012
3	Идэржавхлан	4-р түвшин	idereeiderjavkhlан@gmail.com 86069448
4	Э.Дарьдулам	4-р түвшин	e.daridulam@yahoo.com 99686711
5	А.Жангүль	3-р түвшин	94184523
6	Э.Тогтохням	3-р түвшин	17B1NUM0840@stud.num.edu.mn 88384977, 95787482
7	Б.Хулан	3-р түвшин	99969633, 99687833
8	Э.Энхзул	3-р түвшин	18B1NUM3340@stud.num.edu.mn 89184177, 93014188
9	О.Энхсаруул	3-р түвшин	14B1SAS4733@stud.num.edu.mn 98114861

10	М.Батчимэг	2-р түвшин	20B1NUM1836@stud.num.edu.mn 80217112, 99865812
11	Б.Лхамжаргал	2-р түвшин	20B1NUM2752@stud.num.edu.mn 88384009, 99591004
12	Б.Азжаргал	1-р түвшин	21B1NUM3010@stud.num.edu.mn 88368341, 99311814
13	А.Анужин	1-р түвшин	21B1NUM1051@stud.num.edu.mn 86544559, 88757785
14	Т.Бадам-Очир	1-р түвшин	19B1NUM2108@stud.num.edu.mn, 80906120, 99227045
15	Н.Ичинхорлоо	1-р түвшин	20B1NUM0358@stud.num.edu.mn 95643220, 95023220
16	Г.Пэлжидмаа	1-р түвшин	18B1NUM1697@stud.num.edu.mn 94787006, 89160636
17	О.Хажидмаа	1-р түвшин	21B1NUM1173@stud.num.edu.mn 950509158

III. Ажил олгогчдын нэрс


№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал	Биологийн багш	Цахим хаяг, утас
1	Б.Амармандах	Хэнтий, Хэрлэн, 4-р сургууль	Сургалтын менежер	Болор-Эрдэнэ	mandah.b8080@gmail.com 88053811
2	М.Мөнхцэцэг	Улаанбаатар, 126-р сургууль	Сургалтын менежер	Ц.Болорзаяа	muugii60@gmail.com 99065126
3	Д.Уранцэцэг	Улаанбаатар, 52-р сургууль	Сургалтын менежер	Б.Саруул	Urantsetseg521@gmail.com 99291980
4	Л.Отгонбаяр	Баянхонгор, Төгс Алгоритм	Сургалтын менежер	Н.Нандин-Эрдэнэ	otgonbayar.luv@gmail.com 89005095
5	Ч.Аюурзана	Улаанбаатар, 126-р сургууль	Сургалтын менежер	Р.Золжаргал	ayurzana1967@gmail.com 96059650
6	Д.Энхтүвшин	Улаанбаатар, 126-р сургууль	Сургалтын менежер	н.Хатанчимэг	Enkhtuvshin.d@jargalan.edu.mn 89898740
7	А.Болдмаа	Улаанбаатар, 126-р сургууль	Сургалтын менежер	Д.Чанцалдулам	boldmaa.333@gmail.com 85113379
8	И.Дашцэрмаа	Спортын төрөлжсөн дунд сургууль	Сургалтын менежер	Х.Отгонням	Dashtsermaaish@gmail.com
9	Б.Булгамаа	МУИС Лицей ахлах сургууль	Сургалтын менежер	Ё.Даваасүрэн	Bulgamaa@num.edu.mn

10	А.Болдмаа	50-р сургууль	Сургалтын менежер	М.Умитгер	Boldmaa.333@gmail.com
11	Т.Цэрэнханд	5-р сургууль	Сургалтын менежер	Х.Оюунжаргал	tserenkhandtumurbaatar@gmail.com
12	Л.Нямхүү	Этүгэн дээд сургууль	Салбар сургуулийн захирал	Д.Оюунэрдэнэ	Nyamkhuu@etugen.edu.mn 98160606, 99031527
13	Т.Жаргалсайхан	Улаанбаатар 77-р сургууль	Ахлах менежер	С.Оюунтөгс П.Дуламсүрэн	Thsaihan2013@gmail.com 99195931
14	Б.Хонгорзул	Сэлбэ сургууль	Захирал	П.Махбал	khongoroo@gmail.com 89009496
15	Д.Пүрэвдорж	Завхан Жавхлант цогцолбор сургууль	Захирал	н,Батболд Ё.Дэлгэрмаа	Yeszavkhan@gmail.com 95336333

IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Цахим хаяг, утас
1	Б. Саруул	2020	Хан-Уул 52-р сургуулийн багш	Saruul8010@gmail.com 96728010
2	Р.Золжаргал	2020	Эрдмийн Ундраа цогцолбор сургуулийн багш МУИС-ийн магистрант	zoloozok0629@gmail.com 89134195
3	Б.Уянга	2020	Ирээдүй цогцолбор сургуулийн ба МУИС-ийн магистрант	buuraluyanga@gmail.com 94144426
4	Д.Буниа	2020	MCS компанид микробиологич	Bunia.dagvadorj@gmail.com 89234578
5	Б.Чандмань	2021	УБ 93-р сургууль	chandmani.9999@gmail.com 89404042
6	Э.Тамир	2021	УБ 107-р сургууль	Tamirtatanya@gmail.com 88172958
7	Г.Батнасан	2017	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн криминалистикийн шинжилгээний газрын экологийн шинжилгээний лабораторийн шинжээч, МУИС-ийн докторант	Batnasan9947@gmail.com 89840454
8	Т.Умитгер	2018	УБ 50-р сургууль	Umitgers63@gmail.com
9	Х.Оюунжаргал	2015	УБ 5-р сургууль	Oyunaa00002@gmail.com 99227651
10	Б.Жавхлан	2014	Солонгосд боловсрол судлалаар докторантурт сурч байгаа	jawkhlan.bayanmunkh@gmail.com
11	Э.Бибиш	2014	Хан-уул 32-р сургууль	Erdenebaatar.bibi@gmail.com
12	Н.Уранбилэг	2014	СБД 4р сургууль	narantuyauranbileg09@gmail.com
13	Х.Сосорбурам	2014	46-р сургууль	khurleesoosoo@gmail.com
14	О.Баясгалан	2014	Монгол билиг оюун	bayasgalan.o@mbo.edu.mn
15	Ж.Сугаржаргал	2014	Хөвсгөл Цагаан уул ЕБС	sugarjargalsugarjargal@gmail.com
16	Б.Мөнгөнжин	2014	Титэм ЕБС	bmunguunuu1111@gmail.com
17	Б.Мөнхнасан	2014	НИХТ	nasuka.batbayr@gmail.com

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
14201 Улаанбаатар хот-46а ш/х-330, Сүхбаатар дүүрэг,
Баян тойруу 47, Утас/Факс: (976-11) 32-54-35,
E-mail: sae@num.edu.mn, http://sas.num.edu.mn

2022.04.04 № 70/268
тантай _____-ны № _____-т
Шинжээчийн тайлангийн хариу хүргүүлэх тухай

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД


Тус сургуулийн Биологийн тэнхимээс эрхлэн хэрэгжүүлж буй Багш, Байгалийн ухааны боловсрол (Биологи)-ын бакалаврын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааны шинжээчийн баг 2022 оны 03 дугаар сарын 15-16-нд МУИС дээр ажиллан мэргэжлийн түвшинд үнэтэй санал зөвлөмж ирүүлсэнд талархаж байна. Манай хөтөлбөрийн баг БМИУЗ-өөс томилогдсон шинжээчийн багийн тайлантай нэг бүрчлэн танилцсан бөгөөд зөвлөмжийг хүлээн авч түүний талаарх одоогийн нөхцөл байдал, биелүүлэх боломжтой саналыг хүргүүлж байна.

Мөн 7-р шалгуурын 2 шаардлагыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд 1, 2, 5-р шалгуурын шаардлагуудын хүрээнд хариу саналыг нотлох материалуудын хамт хүргүүлж байна.

Шинжээчийн багаас ирүүлсэн зөвлөмжийг бид цаашдын үйл ажиллагаандаа тусган, хөтөлбөрөө тогтмол сайжруулахаа үүгээр илэрхийлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт...хуудастай

ХӨТӨЛБӨРИЙН БОДЛОГО,
ДОТООД ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
БАЙГАЛИЙН УХААНЫ
САЛБАР ХАРИУЦСАН
ДЭД ЗАХИРАЛ



Б.БАТЖАРГАЛ

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) 2022.05.03

Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжилсэн	5 жил

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) 2022.05.12

Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
Магадлан итгэмжилсэн	5 жил